



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 1/86

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан хоёр иргэний дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр баазад тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эко Стар ХХК-ийн "Эко стар" зочид буудлын 13/129, Хонгконглүүү ХХК-ийн "Хонг Конг" зочид буудлын 13/98 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 07 өдрийн
А/86 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ЖАГСААЛТ

2016.09.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Хонгконглююу ХХК	Хонг Конг	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, Москва 10
2	Эко Стар ХХК	Эко Стар	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 91/4

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 07 өдрийн
А/86 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ЖАГСААЛТ

2016.09.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эм Эм Эм Ди ХХК	Кэйзер	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 10/2в
2	Зургаан талт ХХК	Аппле	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2016 оны 09 сарын 07 өдрийн А/86 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭДИЙН
ЖАГСААЛТ


2016.09.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ж.Энхбаатар	Лассо	Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 43/1
2	Иргэн Б.Бадамцэцэг	Коко	Баянгол дүүрэг, 7-р хороо, Жамсранжавын гудамж 40

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 07 өдрийн
А/86 дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.09.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Монголий Вояж ХХК	Мөнх тэнгэр-2	Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Тайны амын зүүн ам

-ooOoo-